МЭДЭЭ · 2026 оны 3-р сарын 30

ХҮҮХЭД ХОХИРСОН ХЭРГҮҮДИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 27-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 48,358 эрүүгийн хэрэгт хяналт тавьжээ.

Дээрх хугацаанд 1,639 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол хэрэг бүртгэлтийн 732 хэрэг шинээр нээж, 343 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдсэн байна.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 133, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 80, Өмчлөх эрхийн эсрэг 74, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг болон Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг тус бүр 9, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг болон Авлигын эсрэг гэмт хэрэг тус бүр 8, Хүний амьд явах эрхийн эсрэг 5, Кибер аюулгүй байдлын эсрэг болон Эдийн засгийн гэмт хэрэг 4, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг болон Хэрэг хянан шалгах ажиллагааны эсрэг тус бүр 3, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг 2, Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 1 яллах дүгнэлт үйлдсэн байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 133 гэмт хэргийг зүйлээр нь авч үзвэл,

Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 8, хүндэвтэр хохирол санаатай учруулах 16, хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах 1, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах 105, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 3 хэрэг байна.



Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн зарим хэргээс дурдвал:

-Б.Б нь нийтийн албан тушаалтнаар буюу ...нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн дэмжих, урьдчилан сэргийлэх төвийн эрхлэгчээр ажиллаж байхдаа эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан багш, ажилчдын үзлэгийн төлбөрийн мөнгийг “байгууллагын дансанд тушаана” гэх нэрийдлээр бусдын дансаар шилжүүлэн хувьдаа авч, өөртөө эдийн засгийн давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны тойргийн шүүхэд;

-Б.М, Е.С нь нар нь харилцан тохиролцож, Е.С-ийн 11 настай хүүхдээр уралдааны морь унуулж, сар бүр 500 мянган төгрөгийн цалин өгөхөөр гэрээ байгуулж, Дорнод аймгийн нутагт дэвсгэрт 2024 оны 4 дүгээр сараас 2025 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд хурдан морь унуулж, хүүхдийн эрүүл мэндэд хохирол учруулахуйц хөдөлмөр эрхлүүлсэн, улмаар 2025 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр хохирогч хүүхдээр хориглосон цаг хугацаанд хамгаалах хэрэгсэлгүйгээр морь унуулсны улмаас хүүхэд мориноос унаж, эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учирсан хэрэгт Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх), мөн хуулийн 11.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах)-т зааснаар Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

-"В..." ХХК нь химийн хорт, аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл авалгүйгээр

үйлдвэрийн тоног төхөөрөмжийг цэвэрлэх, ариутгах зорилгоор 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 224.3 килограмм натрийн гидроксид, 73.9 килограмм устөрөгчийн хэт исэл зэрэг химийн бодисыг худалдан авч, хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулж, хадгалсан хэрэгт Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг (Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

-Гадаадын хөрөнгө оруулалттай “Ш.....” ХХК нь химийн хорт, аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөлгүй атлаа 2025 оны 6 дугаар сарын 28-ны өдөр бусдаас этилийн спирт, цууны хүчил, натрийн гидроксид зэрэг химийн бодисыг худалдан авч, улмаар Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байрлах үйлдвэрийн байранд хадгалсан хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, Хэнтий аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

Баянгол дүүргийн прокурорын газраас:

- М.Э нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 2023 оны 3 дугаар сарын 06-аас 07-нд шилжих шөнө Баянгол дүүргийн 10 дугаар хороонд байрлах гэртээ 3 настай дагавар хүүг хүчиндэхийг завдсан, улмаар энэ үйлдлээ нуун далдлах зорилгоор онц, харгис хэрцгийгээр зодож, хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй болохыг мэдсээр байж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, бага насны хүүхдийг алсан хэрэгт Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг (Бага насны хүүхдийг хүчиндэх), 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.4, 2.7, 2.8 дахь заалтад зааснаар,

- Ц.Л нь хамтран амьдрагч М.Э нь хүүг нь зодож, эрүүл мэндэд нь хохирол учруулсан байхад хүүхдийг асран хамгаалах үүргээ биелүүлээгүй, эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй үзүүлээгүйн улмаас хохирогч 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүнд гэмтлийн улмаас нас барсан хэрэгт Эрүүгийн хуулийн 16.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг (Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд тус тус шилжүүллээ.

> Прокуророос яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн хэргийг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хянан хэлэлцэж, гэм буруутай гэж үзвэл хуульд заасан эрүүгийн хариуцлага оногдуулдаг хуулийн зохицуулалттай.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/658